

БАГЦ 3

1. Дуулга малгай бүчний хамт

Хамгаалалтын дуулга нь толгойг цохилтоос хамгаалах үндсэн үүрэгтэйгээс гадна механик үйлчлэл, түлэгдэлт, химийн болон хайлсан металлын шүршдэс, очноос хамгаалах ба мөнтүүнчлэн ажилтан санамсаргүйгээр гүйдэлтэй хэсэгт хүрэхэд мөн цахилгаан гүйдэлд цохиулахаас хамгаална.

Хамгаалалтын дуулга нь дараах шаардлагуудыг хангах ёстой. Үүнд:

- 50 Дж цохилтын хүч үйлчлэхэд хамгаалалтын дуулга нь толгойруу 5 кН-оос ихгүй хүчийг дамжуулах ёстой, мөн 30 Дж хүчтэй хурц ирмэг бүхий зүйлс дээрээс унахад тэдгээр нь толгойг цохихгүй байх ёстой;
- Хамгаалалтын дуулганы их бие нь цахилгаан гүйдэлтэй эд ангид хүрэхэд 50 Гц-ийн давтамжтай 440В-оос багагүй хүчдэлийн хувьсах гүйдлээс хамгаалах ёстой;
- Хамгаалалтын дуулга нь үйлдвэрлэгчээс тодорхойлсон дулааны дээд доод хязгаарт хамгаалах чадвараа хадгалах ёстой. Хамгаалалтын дуулга бүр түүнийг хэрэглэх температурын дээд доод хязгаар болон цахилгаан тусгаарлах чадварыг заасан арилахааргүй (сийлсэн, цохисон) тэмдэг, тэмдэглэгээтэй байх;
- Хамгаалах дуулга нь толгойноос унах, холбиорохоос сэргийлсэн бэхэлгээтэй байх;
- Хамгаалах дуулга эрүүн доогуурх бүчтэй бол түүний өргөн нь 10 мм-ээс багагүй байх ба бүч болон түүний бэхэлгээний бат бэхийн дээд хязгаар нь 150 - 250 Н байна;
- Туршилтын үед хажуугийн хэв гажилт нь 40 мм-ээс ихгүй, үлдэгдэл хэв гажилт нь 15 мм-ээс ихгүй байх;
- Хамгаалах дуулгыг толгойдоо анх тохируулан өмссөнөөс хойш хэрэглэх нийт хугацааны туршид түүний тохиргоо өөрөө өөрчлөгдөх ёсгүй;
- Үйлдвэрлэгч толгой хамгаалах хэрэгслийн ашиглалтын баримт бичигт түүнийг хэрэглэх температур, нөхцөл, цахилгаан тусгаарлах чадвар зэргийг заасан байх ёстой.
- Өндөр болон (эсвэл) нам температурын үйлчлэл, дулааны цацрагийн үйлчлэлээс хамгаалах дуулга нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:
- Хамгаалалтын дуулга нь хайлсан металлын шүрсдэс, очийг дотогш нэвтрүүлдэггүй байх (их биед хайлсан металлын шүрсдэс хүрснээс хойш 5с-ын дараа дөлний шаталтыг зогсоодог байх ёстой);
- Хамгаалалтын дуулга нь ердийн агааржуулалттай байх бөгөөд хэрэв агааржуулалтгүй бол доторх чийгийг шингээх хэрэгсэлтэй байна;
- Өндөр температуртай орчинд гүйцэтгэх ажилд зориулагдсан хамгаалалтын дуулга нь үйлдвэрлэгчийн заасан гадна агаарын температурын дээд доод хязгаарт өөрийн хамгаалах чадвараа хадгалах ёстой;

Тохирлын баталгаа: EN 397

3М Н-700 загварын дуулгатай дүйцэхүйц байх.

Шаардлагатай тоо ширхэг – 200 ширхэг

2. Резин бээлий

Дотор талаасаа хальсан шүрсдэстэй таван хурууны бээлий.

Үндсэн материал: 100 % натурал латекс.

Шүршдэс: бактерийн эсрэг үйлчилгээтэй хөвөн материал.

Протеины агууламжгүй (харшил өгөхөөргүй).

Алганы хэсэг ромб хэлбэрийн болон хайрслаг биржгэртэй байж болно.

Бүтцийн хэсгүүд болон материалд тавигдах шаардлага

Үндэслэл	
Материал	Нимгэн латексан бээлий хөвөн материалан доторлогоотой
Урт нь 30см багагүй, хамгаалалтын бүрхүүлийн зузаан 0,38 мм-ээс багагүй	
Материал	Латекс
Элэгдэх байдал	1
Зүсэгдэх эсэргүүцэл	0
Урагдах эсэргүүцэл	1
Цооролт тэсвэрлэлт	0

Тохирлын гэрчилгээ: EN 388, EN 374-1, EN420

Зориулалт: 20%-ийн хүчил, шүлт хэрэглэдэг технологийн тоног төхөөрөмжид ажил гүйцэтгэх болон аж ахуйн ажилд хэрэглэнэ.

Шаардлагатай тоо ширхэг – 2000 хос

3. Хүчил, шүлтэнд тэсвэртэй резин бээлий

Бензин, тосонд тэсвэртэй хөвөн материалтай резинэн, таван хурууны урт бээлий.

Бүтцийн хэсгүүд болон материалд тавигдах шаардлага

ҮНДЭСЛЭЛ	
Материал	Нимгэн нитрилэн бээлий хөвөн материалан доторлогоотой
Урт нь 33см багагүй, хамгаалалтын бүрхүүлийн зузаан 0,45 мм-ээс багагүй	
Материал	Нитрил
ҮЗҮҮЛЭЛТ	
Элэгдэх байдал	3
Зүсэгдэх эсэргүүцэл	1
Урагдах эсэргүүцэл	0
Цооролт тэсвэрлэлт	1

Протеины агууламжгүй (харшил өгөхөөргүй).

Тохирлын гэрчилгээ: EN 388, EN 374-1, EN 420.

Зориулалт: 80% хүртэлх концентрац бүхий хүчил, шүлттэй харьцаж ажиллах, түүнчлэн дунд зэргийн механик ачаалалтай ажил гүйцэтгэхэд хэрэглэнэ.

Шаардлагатай тоо ширхэг – 300 хос

4. Дуу чимээний эсрэг чихний бөглөө

Сонсголын эрхтэн хамгаалах хэрэгслийн үндсэн үүрэг нь сонсголын эрхтний дуу чимээнд мэдрэг сувгийн мэдрэмжийг бууруулахад оршино. Зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн үед сонсголын эрхтэнг хамгаалах хэрэгсэл. Чихний бөглөө нь нэг удаагийн ба олон удаа хэрэглэгддэг, полимерен материалаар хийгдсэн хооронд нь холбосон уяатай байна. Чихний сувгийн хэлбэрт амархан ордог байх ёстой.

Дууны нөлөөлөл нь /SNR/ 24 ДБ-с багагүй байна.

Тохирлын баталгаа: EN 352-2

Шаардлагатай тоо ширхэг – 10000 хос

5. Химийн бодис, чийг, үйлдвэрлэлийн бусад бохирдлоос хамгаалах комбинезон

Голоороо товчилгоотой, малгайтай, малгайны урд талаар нүүрний хэсгийн дагуу, бугуй, шилбээр резинтэй.

Материал:

Полиэтилен ширхгээс бүрдсэн нэхээсгүй материал, материалын нягт 41г/м³-аас багагүй, 100 удаагийн үрэлтийг даах чадвартай байх. (EN512)

Аюултай хатуу бодисын жижиг хэсгүүд, бодисын тоос, нунтгийн дисперс, концентраци ихтэй органик бус хүчил шүлт, давсны уусмал, 2атм хүртэл даралттай шингэний цалгилтаас ажилтаныг хамгаалах зориулалтын хувцасны материал нь 83г/м³ -аас багагүй нягттай, өнгөн талаараа полимер бүрээстэй полиэтилен ширхгүүдийг дулааны боловсруулалтаар бэхэлсэн нэхээсгүй материал байна. Үрэлт даах чадвар нь 2000 удаагийн үрэлтийг даах түвшинд байна.

Хамгаалалтын үзүүлэлтүүд

Хатуу бодисын жижиг хэсгүүдийн үйлчлэлээс хамгаалах	Дурын хэмжээтэй жижиг хэсгүүдээс 100 хувь хамгаална.
Химийн шингэн бодисын үйлчлэлээс хамгаалах	Дурын концентрацитай органик болон органик бус хүчил шүлт
Усны даралт даах чадвар	300-аас дээш өндрөөс буух
Бактерийн эсрэг хамгаалалт	100%
Цэнэгжилтийн эсрэг боловсруулалт	Дотор гадаргуу

Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ: ГОСТ 12.4.100-80

Шаардлагатай тоо ширхэг – 50 ширхэг